Ректорын 2024. оны 12-р сарын
20. өдрийн А/190 тоот
тушаалын хавсралт №2.

ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛИЙН ОЮУТАНД ТЭТГЭЛЭГ ОЛГОХ, ХӨНГӨЛӨЛТ, УРАМШУУЛАЛ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Отгонтэнгэр их сургууль /цаашид "ОТИС" гэх/-ийн оюутны сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, оюутны ажилдаа гаргасан амжилт, өөрийн манлайлал, идэвх санаачилгыг авьяас, мэдлэг ур чадварыг үндэслэн гаргасан амжилтыг, нь алдаршуулан тэдэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор тэтгэлэг олгох, сургалтын төлбөрийн хөнгөлөлт, урамшуулал үзүүлэхэд энэхүү журам /цаашид "журам" гэх/-ыг баримтална.

1.2. Энэхүү журмын зорилго нь оюутны мэдлэг чадварын түвшин, түүний ахиц, амжилтыг үнэлж урамшуулах, тэднийг хөгжүүлэх, авьяасыг дэмжих, алдаршуулах түүнд үндэслэн сургалтын чанарыг сайжруулах, сургуулиас нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг бэхжүүлэхэд оршино.

1.3. Энэхүү журам нь бакалаврын өдрийн ангийн суралцагчдад болон ОТИС-ийг төгсөөд сургуульдаа ахисан түвшний сургалтад өдрийн хэлбэрээр суралцаж буй магистрант, докторантурын суралцагчдад хамаарна.

Хоёр: Оюутанд олгох тэтгэлэг, хөнгөлөлт, урамшууллын төрөл

2.1. ОТИС-ийн оюутанд олгох тэтгэлэг нь дараах төрөлтэй байна:
- 2.1.1. ОТИС-ийн Үүсгэн байгуулагчийн нэрэмжит тэтгэлэг, батламж
- 2.1.2. ОТИС-ийн Төгсөгчийн нэрэмжит тэтгэлэг

2.2. ОТИС-ийн оюутанд олгох сургалтын төлбөрийн хөнгөлөлт, урамшуулал нь дараах төрөлтэй байна.
- 2.2.1. ОТИС-ийн Амжилтын эзэн хөнгөлөлт, урамшуулал
- 2.2.2. ОТИС-ийн Авьяаслаг оюутан хөнгөлөлт, урамшуулал
- 2.2.3. ОТИС-ийн ОХ, зөвлөлийн гишүүдийн хөнгөлөлт, урамшуулал

2.3. ОТИС-ийн оюутанд олгох урамшуулал нь дараах төрөлтэй байна:
- 2.3.1. ОТИС-ийн Манлайлагч батламж
- 2.3.2. ОТИС-ийн Манлайлагч шилдгийн шилдэг оюутан
- 2.3.3. Манлайлагч тэргүүний оюутан
- 2.3.4. Манлайлагч удирдагч оюутан
- 2.3.5. Манлайлагч судлаач оюутан
- 2.3.6. Манлайлагч клубийн удирдагч оюутан Шилдэг төв, клуб, дугуйлан
- 2.3.7. Манлайлагч анги хамт олон

Гурав. Тэтгэлэг, хөнгөлөлт, урамшуулалд хамрагдах оюутнуудад тавигдах шалгуур

3.1. Тэтгэлэг, хөнгөлөлт, урамшуулалд хамрагдах оюутнууд дараах нийтлэг шалгуур, шаардлагыг хангасан байна:
- 3.1.1. ОТИС-ийн дүрэм, дотоод журам болон суралцах гэрээгээ зөрчөөгүй байх
- 3.1.2. шалгалтын болон өмнө жилийн төлбөрийн үлдэгдэл тооцоогүй байх
- 3.1.3. анги хамт олны дунд нэр хүндтэй, нийгмийн идэвхтэй байх
- 3.1.4. Тэтгэлэг, хөнгөлөлт, урамшуулалд хамрагдах оюутнууд дараах тусгай шалгуур, шаардлагыг хангасан байна:
- 3.1.5. ОТИС-ийн Үүсгэн байгуулагчийн нэрэмжит тэтгэлэг

3.1.5.1. 1-р улирлаасаа эхлэн 2-3 улирал дараалан 90 ба түүнээс дээш үнэлгээтэй суралцвал дараа улирлын сургалтын төлбөрөөс 500,000 төгрөгөөр /улирлын дүнд дахин шалгалтын дүнг тооцохгүй/;

3.1.5.2. 1-р улирлаасаа эхлэн 4-7 улирал дараалан 90 ба түүнээс дээш үнэлгээтэй суралцвал дараа улирлын сургалтын төлбөрөөс 600,000 төгрөгөөр /улирлын дүнд дахин шалгалтын дүнг тооцохгүй/;

3.1.5.3.хичээлийн улирлын эхний долоо хоногт өмнөх сургалтын хугацааны сурлагын өндөр амжилт гарган суралцсан тэргүүний оюутанд "ОТИС-ийн Үүсгэн байгуулагчийн нэрэмжит тэтгэлэг"-ийг ОТИС-ийн ректорын тушаалаар баталгаажуулж тэтгэлгийг сургалтын төлбөрийн хөнгөлөлт хэлбэрээр олгоно.

3.1.6.ОТИС-ийн Төгсөгчийн нэрэмжит тэтгэлэг

3.1.6.1.Жил бүрийн Олон улсын оюутны эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ОТИС-ийн 2-4 дүгээр курсийн оюутнуудаас сурлагын амжилт, олон нийтийн оролцоо, манлайллаараа шалгарсан шилдэг оюутнуудыг тусгай удирдамжийн дагуу шалгаруулж, тус бүрд сард 100,000 төгрөг нийт 7 сард 700,000 төгрөгийн тэтгэлэг олгоно.

3.1.6.2.ОТИС-ийн Амжилтын эзэн

3.1.6.3.ОТИС-ийн нэрийн өмнөөс олон улс, улсын чансаа өндөртэй эрдэм шинжилгээний хурал, олимпиад, спорт, урлагийн уралдаан тэмцээнд холбогдох тэнхимийн тодорхойлолт, бүтцийн сургуулийн захирлын зөвшөөрлийн дагуу амжилттай оролцож эхний гурван байрт, тусгай байрт шалгарсан, Сургалтын төлбөрийн хөнгөлөлт нь амжилт гаргасан тухайн улиралд хамаарна. /Тэмцээн, уралдааны нэр төрлийг давхцуулан олгохгүй/ Үүнд:

Олон улсын хэмжээнд:

I байрт шалгарсан оюутанд 400,000 төгрөг хүртэл
II байрт шалгарсан оюутанд 300,000 төгрөг хүртэл
III байрт шалгарсан оюутанд 200,000 төгрөг хүртэл
Тусгай байрт шалгарсан оюутанд 100,000 төгрөг хүртэл

Улсын хэмжээнд:

I байрт шалгарсан оюутанд 300,000 төгрөг хүртэл
II байрт шалгарсан оюутанд 200,000 төгрөг хүртэл
III байрт шалгарсан оюутанд 100,000 төгрөг хүртэл

3.1.7.ОТИС-ийн Авьяаслаг оюутан хөнгөлөлт

3.1.7.1.ОТИС-ийн Сагсан бөмбөгийн шигшээ багийн эрэгтэй 15, эмэгтэй 15 тамирчны бүрэлдэхүүнд багтсан тамирчин оюутан нь ёс зүйтэй хариуцлагатай, сурлага, спортоороо бусдадаа үлгэр дуурайлалтай байж тэмцээн уралдаанд оролцож амжилт гаргасан үр дүнд нь үндэслэн 100 хувь хүртэл хэмжээгээр дараах шалгуур, шаардлагыг хангасан бүх тамирчдад сургалтын төлбөрийн хөнгөлөлтийг үзүүлж болно.

3.1.7.2.ОТИС-ийн Сагсан бөмбөгийн шигшээ багийн тамирчин оюутан нь хичээлийн цагийн таслалтгүй, сурлагын голч дүн 2.5-оос дээш байх /улирлын голч дүнд дахин шалгалтын дүнг тооцохгүй/

3.1.7.3.ОТИС-ийн Сагсан бөмбөгийн шигшээ багийн бэлтгэлд бүрэн хамрагдсаныг багш-дасгалжуулагч баталгаажуулсан байх

3.1.7.4.тухайн хичээлийн жилд гаргасан багийн амжилт болон хувь тамирчин оюутны багт гүйцэтгэсэн үүргээс хамаарч багш дасгалжуулагчийн тодорхойлолтоор үр дүн амжилтыг дүгнэнэ.

3.1.7.5.сагсан бөмбөгийн шигшээ багийн тамирчныг дүгнэх, тодорхойлох үзүүлэлт, явцыг тусгай гэрээ байгуулж зохицуулна.

3.1.8.ОТИС-ийн ОХ, оюутны зөвлөлийн гишүүдийн хөнгөлөлт, урамшуулал

3.1.8.1.хичээлийн жилийн эхний долоо хоногт Олон улсын оюутны эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ОХ-ны идэвхтэн гишүүдэд ОХ-оос ирсэн хүсэлт, тодорхойлолт, өнгөрсөн хичээлийн жилийн гүйцэтгэсэн ажлын үр дүнг харгалзан дараа улирлын сургалтын төлбөрөөс 300,000 төгрөг хүртэл хөнгөлөлт үзүүлнэ.

3.1.8.2.Олон улсын оюутны эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ОЗ-ын идэвхтэн гишүүдэд ОЗ-өөс ирсэн хүсэлт, тодорхойлолт, өнгөрсөн хичээлийн жилийн

гүйцэтгэсэн ажлын үр дүнг харгалзан дараа улирлын сургалтын төлбөрөөс 300,000 төгрөг хүртэл хөнгөлөлт үзүүлнэ.

3.1.8.3.идэвхтэн гишүүдийн тодорхойлолтыг ОЗ-ийн чиглүүлэгч багш тодорхойлон, хэлэлцсэн хурлын тэмдэглэлийг хийсэн ажлын тайлангийн хамт ректорын зөвлөлд ирүүлэх бөгөөд зөвлөлөөр хэлэлцэн ректорын тушаал гарган сургалтын төлбөрийн хөнгөлөлт хэлбэрээр жилд 1 удаа олгоно.

3.1.9. ОТИС-ийн Манлайлагч батламж

3.1.9.1.Олон улсын оюутны эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ОТИС-ийн нийт оюутнаас бүтцийн сургуулийн хэмжээнд сурлага, эрдэм шинжилгээ судалгаа, урлаг спортын амжилтаараа хошуучлан манлайлсан оюутныг тусгай удирдамжийн дагуу шалгаруулж, батламж, оны манлайлагч медаль гардуулж, олон нийтэд сурталчлан хүндэтгэлийн самбарт зургийг нь байршуулан алдаршуулна.

3.1.9.2.болзол хангасан оюутны хүсэлтийг харгалзан анги удирдсан багш тодорхойлж, харьяа тэнхимийн хурлаар хэлэлцэн нэр дэвшүүлж бүтцийн сургуулийн бүх багш нарын хурлаар хэлэлцүүлэн энэхүү журмын 2.3 номинациар шалгаруулан ректорын тушаалаар баталгаажуулан зохион байгуулах комисст холбогдох материалыг ирүүлнэ.

3.1.9.3.энэхүү журмын 2.3.1.1-д бүтцийн сургууль тус бүрээс шалгарсан Манлайлагч тэргүүний оюутанд 3 оюутны материалыг үндэслэн ректорын зөвлөлийн хурлаар хэлэлцэн ОТИС-ийн Манлайлагч шилдэг оюутныг шалгаруулна.

3.2. ОТИС-ийн оюутан нь энэхүү журмын 2.1-2.2-д заасан тэтгэлэг, хөнгөлөлт урамшууллыг давхардуулан эдлэхгүй бөгөөд зэрэг эдлэхээр шалгуур хангасан бол аль нэгийг нь эдлэхээ оюутан өөрөө сонгох эрхтэй.

---o0o---